БАТЛАВ:
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТ-ЭРДЭНЭ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны хэсэгчилсэн дотор засвар, гадна фасад, цонх хаалганы засварын ажил:

/Уг барилга нь Дорноговь аймгийн Иххэт суманд байрлах тэнхлэгээрээ 69.0м х 27.1м хэмжээтэй шугаман суурьтай, 510мм тоосгон ханатай, хавтгай дээвэртэй 2 давхар барилга./

А.Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны хэсэгчилсэн дотор засварын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНбД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

Б. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

В. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах

Г. Үнийн саналд зураг төслийн үнийг **25 683 600 /Хорин таван сая зургаан зуун наян гурван мянга зургаан зуун/** төгрөгөөр тусгаж ирүүлэх ба Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-12*(2020)-г мөрдлөг болгоно.

Д. Барилгын угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.

1. Буулгалтын ажил

- Одоо байгаа хуучин будагтай хана, багана, дам нуруу, таазны гадаргууг хусаж цэвэрлэх. Тоосгон хананы хөндийрч суларсан шаврыг буулгах.
- Шалны плита, паркет шалыг задлаж буулгах. Цэвэр ба хар банзан шалны хадаасыг сугалж хуулах. Шалны хуучин хулдаас хуулах.
- Ариун цэврийн өрөөний ханын хавтанцар өнгөлгөөг буулгах /16 дугаар өрөө/.
- Хамар ханын тоосгон өргийг гараар ухаж буулгах /10,16,24,26,27,28,29,43,44 дугаар өрөө/
- Хуучин шугам хоолой задлаж буулгах ф25мм, ф50мм, бохирын ширмэн хоолой задлаж буулгах ф100мм, хуучин угаалтуур,суултуур буулгах.
- Одоо байгаа цонх, хаалга, хаалга цонхны гадна дотор амалгааны шавардлага, четверт өргийг зүсэж, ханын хөндийрсөн шавардлага цэвэрлэж буулгах.
- Тоосгон ханын хуучин цонх,цонхны тавиур, хаалга задлаж буулгах.
- Барилгын буулгалтаас гарсан хог шороог ачиж зайлуулан, барилгын талбай цэвэрлэнэ.

2. Шалны ажил

- Шалны доор овойлтгүй хөрс 150-200мм зузаан шороо хийж үечилэн нягтруулна. Бетоны дэвсгэр үе хийх БМ100 байна. 20мм зузаан цементэн тэгшилгээ хийх, бүрэн бэхжилтээ авсны дараа хулдаас /7,25 өрөө/, паркет /8,10,17,19,20,25,26,27өрөө/, плита /11,12,24,35,40,41,42/шалын угсралтын ажлыг гүйцэтгэнэ.

- Ариун цэврийн өрөө, агуулахын шаланд плитан хавтан угсрах /300-300мм/ 1,2 дугаар давхрын коридорт цементэн зуурмаг дээр чулуун өнгөлгөөтэй хавтанцар наах. Спорт заалны шаланд суурь түрхлэг хийж резинэн будгаар 2 удаа будах. Анги танхимын шалыг 35%-с дээш цэвэрлэж сайн чанартай будах.

3. Дотор заслын ажил:

- Өрөө тасалгааны хананд тэгшилгээ өнгөлгөөг хийнэ. Тэгш өнцөгт багана, дам нуруу шавардах. Угсармал хавтгаалжин таазанд засал хийх, Гипсэн хавтангаар таазанд өнгөлгөө хийх /23,34 өрөө/, замаскан тэгшилгээ хийж сайн чанарын эмульсэн будгаар будах. Өнгөт хавтангаар h=90см явган хана /6,26,34 өрөө/ хийж, явган хананаас дээш товгор хээтэй сайн чанарын обойгоор цааслах.

- Урлаг заалны хана аккустик хавтангаар өнгөлөх. Карказан ханыг өнгөт хулсан хавтангаар бүрэх. Коридорын хананд h=2м тэгшилгээ хийж өнгийн тосон будгаар гар аргаар сайн чанартай будах, 2м-с дээших хананд тэгшилгээ хийж эмульсэн будгаар будах.

- Ариун цэврийн ереений =2.4м хананд 450+300мм-ийн өнгөлгөөний хавтанцар нааж, h=24м-с дээших хананд ус чийгэнд тэсвэртэй сайн чанарын эмульсэн будгаар будах. Ариун цэврийн өрөөний хананд бэлэн өнгөлгөөтэй модон хийцээр угсрах. Хамар хана /40,41,42/-р өрөөнд, хаалга Битүүлж шинээр өрөх.Тоосгоор энгийн гоёлтой 250мм-ийн тоосгон хана цемент шохойн зуурмагаар гагнаж өрөх. Шинээр өрсөн хана цементэн зуурмагаар гараар шавардах. Хананд тотгон гэгээвч суулгах /6,8-р өрөө/.

4. УС ХАНГАМЖ:

- Тус барилгын унд ахуйн хэрэгцээний ус нь төвийн шугамаас хангагдана. Ус хангамж нь зоорийн давхар дахь №21 өрөөнд байрлах цэвэр усны хэмжүүрийн зангилаанаас түгээгдэн тоног төхөөрөмжид холбогдоно. Усны найрлага нь MN900-2005 ундны усны стандарт, шаардлагыг хангасан байх шаардлагатай.

- Ариун цэврийн болон гал тогооны усан хангамжийн хэвтээ шугам зоорийн давхарт бүрэн солигдоно. Ариун цэврийн өрөөний босоо шугам, тоноглолууд солигдохгүй. Гал тогооны өрөөний тоноглол босоо шугам бүрэн солигдоно. Усан хангамжийн түгээх шугам болон босоо шугамыг HOPE (High-Density polyethylene) хуванцар хоолойгоор угсарна.

- Цэвэр усны хоолойг угсарч дууссаны дараа БНбД 3.05.01-88-ийн ажлын даралтыг 1,5-аар нэмэгдүүлэн даралтаар шахаж шалган илэрсэн зөрчлийг арилган акт үйлдэж, бүх яндан хоолойг диаметрт нь тохирсон зөөлөн зориулалтын материалаар дулаалах ба гол шугамуудыг 40мм зузаантай, салбар шугамуудыг 30мм-ийн зузаантай дулаална. Ус хэмжүүрийн зангилаа нь цайрдан ган хоолой байх ба яндан хоолойн гагнуурын ажлыг БНбД 3.05.01-88-ийн 5.3-аас 5.13-р зүйлүүдийг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй. Ус хэмжигчийн дараагаас хуванцар хоолойгоор угсарна.

Ундны усны шугам хоолойг эрүүл ахуйн шаардлага хангасан мэргэжлийн байгууллагаар баталгаажсан шугам хоолойгоор угсарна.

5. ХАЛУУН УС:

- Дулааны зангилаанд ф50мм даралт тохируулах хаалт 1ш, ф50мм ус хэмжигч тоолуур 1ш, манометр 2ш, ф50мм хог шүүгч 1ш, ф15мм винтель 4ш , ф20мм бөмбөлгөн хаалт 1ш, ф50мм бөмбөлгөн хаалт 1ш угсарна.

- Ахуйн хэрэгцээний халуун усыг тус барилгын гал тогооны өрөөний ажилчдын ариун цэврийн өрөөд АТМОР брэндийн 50л эзлэхүүний бойлер 1ш, аяга таваг угаах хэсэгт АТМОР брэндийн 25л эзлэхүүний бойлер 1ш, сурагчдын угаалтуурт АТМОР брэндийн 25л эзлэхүүний бойлер 1ш угсарна. Халуун, хүйтэн усны хоолойг диаметрт нь тохирсон зөөлөн зориулалтын материалаар дулаалан угсарна.

6. БОХИР УС:

- Барилгын бохир ус зайлуулах шугам нь зоорийн давхарт таазанд бэхлэн угсарна. Гал тогоо болон ариун цэврийн тоног төхөөрөмжөөс гарах бохир ус нь өөрийн урсгалаар явж бохир усны худагт зайлуулагдана.

- Ариун цэврийн болон гал тогооны хэвтээ шугам зоорийн давхарт бүрэн солино. Нийтийн ариун цэврийн өрөөний босоо шугам, тоноглолууд солихгүй. Гал тогооны өрөөний угаалтуур ажилчдын ариун цэврийн өрөө тоноглол босоо шугам бүрэн солих. Ариутгах татуургын шугамыг хуванцар хоолойгоор хийж гүйцэтг холбох хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд нь чанарын гэрчилгээтэй үйлдвэрлэгчээс баталгаа гаргасан.

- Ус хангамж, ариутгах татуургын шугам хоолой, байх шаардлагатай. Угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ техник аюулгүй ажиллагааны норм дүрмийг баримтлан ажиллавал зохино.

-Зоорийн давхрын лагийг соруулж халдваргүйжүүлэх

7. Хаалга, цонх

- Хаалга, цонхыг бүх тоноглолын хамт угсарч дулаалгын шингэн хөөсөөр чигжиж, гадна, дотор амалгаанд шохойн зуурмагаар сайн чанартай шавардлага, суурь цавуун хөрсжүүлэгч, тэгшилгээ өнгөлгөөг хийнэ. Гол орцонд ганжуулсан шилтэй хаалга, ГХ-1, ГХ-2, ГХ-3 галд тэсвэртэй дулаалгатай металл хаалга, Х-1-с Х-5 шилтэй металл хаалга угсрах. Цонхонд хуванцар тавцан, усны хаялага төмөр эдлэл угсрах. Спорт заалны цонхонд төмөр сараалжин хаалт, тосон будгаар 2 үе будах. Цонхны дунд дөр хана өрөх. Зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах.

8. Гадна фасад

- Гадна фасадны өнгийг БА-10, БА-11, БА-12, БА-13, БА-14 хуудаснаас үзэх. Гадна фасадны өнгийг тухайн орон нутгийн цаг агаар, нарны ээвэрлэлттэй уялдуулан өнгөө хурдан алдахгүй байхыг бодолцон гаргасан тул зурагт тусгасны дагуу сонгох, өөрчлөх тохиолдолд захиалагч, зохиогчтой зөвшилцөнө. Барилгын ханыг бүхэлд нь перлит зуурмагаар шавардлага хийх. Шавардлага хийсэн хананд суурь цавуун хөрсжүүлэгч, шагрей өнгөлгөө хийж усан эмульсэн будгаар будах. Эмульс хийсэн гадаргууг лакаар будна. Цоколын хананд шавардлага, шагрей шавардлага хийх.

9. Шилэн хана:

-Металл рамтай шилэн хана угсрахын өмнө төслийн байранд дахин хэмжилт хийвэл зохилтой. Металл рамыг хана, шал, хучилтанд тэлэгч боолтоор тал бүрд 1200 мм-с ихгүй алхамтай бэхлэх. Хаалга босогүй байна. Ханын шил хатжуулсан байх ба хаалганы түвшинд хуулгатай байна. Хаалганы онгойлт ба баруун зүүн гарыг ажлын зурагт заасан дагуу гүйцэтгэх. Шилэн ханын рамыг барилгын хана, таазнаас 0.3-0.5 см зайтай байхаар угсарч, шахдаг хөөсөөр чигжиж битүүмжлэнэ. Шилэн ханын өнгө барилгын хана, шал, дотор заслалын өнгөтэй ойролцоо байна.

10. Хаяавч

-Хаяавч бетоны доорх хөрсийг норгож, трамбовкоор нягтруулах. Хаяавчийг 1000мм-ийн өргөнтэй 100мм зузаантай цутгаж хийнэ. Уг ажлыг гүйцэтгэхдээ БНБД 31-09-05, БНБД 31-10-05 баримтлан ажиллана.

Барилга угсралтын ажилд мөрдөж ажиллах БНбД, стандартууд

Гэрээт ажлыг гүйцэтгэхэд мөрдөж ажиллах Монгол улсын барилгын норм, дүрмүүд БНбД ба стандартууд:

	Норм, дүрмийн нэр	Дугаар
1-р хэсэг. Барилгын үйлдвэрлэл, ажил гүйцэтгэх ба хүлээн авах		
1.1	Барилгын үйлдвэрлэл, ажил гүйцэтгэх ба хүлээн авах үндсэн дүрэм	БНбД 3.01.01-88
1.2	Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт	БНбД 12-01-09
1.3	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх ашиглалтад оруулах дүрэм	ЗГ-ын 2021 оны 212, 213 дугаар тогтоол
1.4	Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх аюулгүй ажиллах арга техникийн нэгдсэн дүрэм	БНбД 3.01.05-90
1.5	Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм I Хэсэг. Ерөнхий шаардлага	БНбД 12-03-04
1.6	Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм II Хэсэг. Техникийн аюулгүй ажиллагаа.	БНбД 12-04-06
1.7	Барилгын талбайн даамлын үлгэрчилсэн дүрэм	УББ 12-204-01
1.8	Ажлын байрны зааварчилгаа өгөх аргачилсан зөвлөмж	БД 12-106-14
1.9	Барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрэм	БД 12-105-07
2-р хэсэг. Тусгаарлалт, хамгаалалтын түрхлэг, заслын ажил		
2.1	Заслын ажил	БНбД 31-10-05
2.2	Шалны ажил	БНбД 31-09-05
3-р хэсэг. Стандартууд		
3.1	Барилгын ажилд хэрэглэх хайрга, буталсан хайрга	MNS 0346:2000

3.2	Барилгын ажилд хэрэглэх дайрга. Техникийн шаардлага	MNS 0390:1998
3.3	Барилгын ажилд хэрэглэх элс. Техникийн шаардлага	MNS 0392:2014
3.4	Бетон зуурмагийг турших арга	MNS 1185:1998
3.5	Барилгын зуурмаг. Техникийн шаардлага	MNS 1228:1987
3.6	Бетон. Сорьцоор бат бэхийг тодорхойлох арга	MNS 1272:99
3.7	Бетоны бат бэхийг шалгах, үнэлэх зарчим	MNS 1920:1999
3.8	Хүнд бетонд хэрэглэх дүүргэгч материал. Техникийн шаардлага	MNS 2803:2004
3.9	Цемент. Техникийн ерөнхий шаардлага	MNS 3091:2008
3.10	Бетон болон барилгын зуурмагт хэрэглэх ус. Техникийн нөхцөл	MNS 3821:1985
4-р хэсэг Ус хангамж, ариутгах татуургын гадна шугам сүлжээ		
4.1	Дотор сантехникийн сүлжээ	БНбД 3.05.01-88
4.2	Технологийн тоног төхөөрөмж дамжуулах хоолой	БНбД 3.05.05-89
4.3	Дотор сантехникийн систем	БНбД40-06-16
4.4	Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер	БНбД 41-01-11

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилга байгууламжийн угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНбД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилга байгууламжийн угсралтын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Гүйцэтгэсэн ажил тус бүрд ил, далд ажлын акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
7. Барилга байгууламжийн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
8. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.

9. Хэрвээ талбайн тохижилт, шугам сүлжээний зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
10. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
12. Монгол Улсын "Барилгын тухай" хуулийн 14.3–т */барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/* 14.4-т */14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ/* 14.5-д */14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно/* 14.6-д */14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил байна/* гэж заасныг үндэслэн гүйцэтгэгч байгууллага **чанарын баталгаа** гаргаж өгнө.

ХЯНАСАН:

ГХБХБГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л. ОЛЗБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ГХБХБГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭРЭНДОЛГОР